



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/178

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Харааны бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулагдах "Хонхтой бөмбөг"-ийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын зардалд 3,163,000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 3,163,000 (гурван сая нэг зуун жаран гурван мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.3-д тусгагдсан Соёл, спортын салбарын хөтөлбөр, төсөл арга хэмжээний "Спортын аварга" хөтөлбөр, төслөөс тооцож гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбат) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Х.Батболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Э.БОЛОРМАА

8400001 0329
Zah A/178 Ba

Засаг даргын 2024 оны
03 дугаар сарын 25-ны өдрийн
А/178 дугаар захирамжийн хавсралт

“ХОНХТОЙ БӨМБӨГ”-ИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧДЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын зүйл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт зардал
1	2	3	4	5	6
1	Ховд-Улаанбаатар орох унааны зардал	Том хүн	7	112,000	784,000
2	Улаанбаатар-Ховд буцах унааны зардал	Том хүн	7	112,000	784,000
3	Улаанбаатар-Хэнтий орох унааны зардал	Том хүн	7	26,500	185,500
4	Хэнтий-Улаанбаатар буцах унааны зардал	Том хүн	7	35,000	185,500
5	Буудал, хоолны зардал	Том хүн	7x5 өдөр	175	1,225,000
Нийт дүн					3,163,000

-oOo-